

“Монгол улсын барилгын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээ” төсөл

Товч мэдээлэл

Хөтөлбөрийн хугацаа: 2017-2020

Гүйцэтгэгч байгууллага:

Барилга, хот байгуулалтын яам
Монгол улсын Засгийн газар

Хамтран хэрэгжүүлэгч/хариуцагч:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам,
Эрчим хүчний яам
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Төслийн санхүүжилт

Нийт төсөв: 8,169,863 ам.доллар
Санхүүжилтын эх үүсвэр:

- ДДБОС 1,269,863 ам.доллар
- Засгийн газар 3,350,000 ам.доллар
- Хувийн хэвшил 3,450,000 ам.доллар
- НҮБХХ 100,000 ам.доллар

Дэлхий дахины ашиг тус

- Төслийн хугацаанд бууруулах ХХЯ: **10,709 тон CO₂-экв**
- Төсөл хэрэгжсний дараах үр дүн: **64,219 тон CO₂-экв-аар тус тус ХХЯ-ыг бууруулна.**

Тогтвортой хөгжлийн зорилт:



Төслийн зорилго, зорилтууд


Энэхүү төслийн зорилго нь Монгол улсад хүлэмжийн хийн ялгарлыг (ХХЯ) бууруулах үндэсний арга хэмжээг барилгын салбарт хэрэгжүүлж, эрчим хүчний хэмнэлттэй технологийн хэрэглээг нэмэгдүүлэх, тус зах зээлийг дэмжих бөгөөд төслийн дараах 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:



Барилгын салбарын өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээ

Сүүлийн жилүүд дэх хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн, эдийн засгийн өсөлтөөс үүдэн хот суурин газруудын орон сууц болон худалдаа үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байна. Цаашид 2020-2030 он гэхэд 140 мянган орон сууц шинээр баригдах хэтийн төлөвтэй байгаа ба үүнтэй зэрэгцэн эрчим хүчний хэрэглээ ч өсөн нэмэгдсээр байна.

График 1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэгцээ, суурь сценари, Питажоул (10^{15} жоул)



Эх сурвалж: Даян Дэлхийн Ногоон Өсөлтийн Хүрээлэн, 2015, Монгол улсын ногоон эрчим хүчний системийн хөгжлийн стратеги 2013-2035

Нийт барилгын салбарын эрчим хүчний хэрэглээнээс харахад 2010-2030 онд ахуйн эрчим хүчний хэрэглээ 1.6 дахин, худалдаа үйлчилгээний салбарын эрчим хүчний хэрэглээ 2 дахин өсөх хандлагатай байна (ДДНӨХ, 2015).

Үндэсний ашиг тус

- ❖ Эрчим хүчний зардал урт хугацаанд буурсанаар өрхийн амьжиргааны зардал багасч, санхүүгийн чадамж сайжирна.
- ❖ Эрчим хүчний хэрэглээг бууруулсанаар нүүрсээр галлах усан болон уурын халаагуур зуух, цахилгаан станцаас гарах цахилгаан, дулаан үйлдвэрлэлийн эрэлт багасч, агаарын бохирдлыг бууруулна. Ингэснээр нийт хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлнө.
- ❖ Орон сууцны оршин суугчдын амьдралын нөхцөл сайжирна.
- ❖ ХХЯ-ыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөөс үүсч болох эрсдлээс урьдчилан сэргийлнэ.
- ❖ ЭХХ-тэй барилгын материалын эрэлт нэмэгдэж, орон нутгийн үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлнэ. Ажил эрхлэлт нэмэгдэж, эдийн засаг сайжирна.
- ❖ Барилгын салбарт ЭХХ-ийн санхүүжилтийн механизмыг бий болгосноор хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- ❖ Барилгын салбарт ажиллагсад, тэр дундаа эмэгтэйчүүдийн ур чадварыг сайжруулж, чадавхи бэхжүүлнэ.

Холбоо барих хаяг:

Төслийн нэгж

Монгол Улс, Улаанбаатар хот 15170, Барилгачдын талбай 3, Засгийн газрын 12 дугаар байр, 405 тоот өрөө

<http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/operations/projects/>

namamongolia@gmail.com

+976-7555-2043

Барилгын салбараас ялгарах хүлэмжийн хийн хэмжээ

2012 оны байдлаар нийт ХХЯ-ын 52.0%-ийг эрчим хүчний салбар ялгаруулсан (БОНХЯ, MARCC-2014) бөгөөд цаашдаа өсөлт энэ хэвээр үргэлжилбэл 2030 он гэхэд 82% буюу 51.2 сая тон CO₂-экв болж 2006 оны суурь үзүүлэлтээс даруй 4 дахин нэмэгдэх таамаглалтай байна.


Хүснэгт 1. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ ба ХХЯ

	2015	2020	2030
Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ (Гвт/жил)	8.64	9.52	11.63
Хүлэмжийн хийн ялгарлын үзүүлэлт (сая тон CO ₂ -экв)	4.94	5.45	6.66

Эх сурвалж: НУБХХ, НАМА төслийн баримт бичиг, 2016

2015 онд барилгын салбар 8.64 Гвт эрчим хүч зарцуулж, 4.94 сая тон CO₂-экв хүлэмжийн хий ялгаруулсан байна. Хэрэв цаашдаа өсөлт энэ хэвээр үргэлжилбэл 2020 он гэхэд барилгын салбар 9.52 Гвт эрчим хүч, 5.45 сая тон CO₂-экв, 2030 онд 11.63 Гвт эрчим хүч, 6.66 сая тон CO₂-экв хүлэмжийн хий ялгаруулах магадлалтай.

График 2. Барилгын салбарын эрчим хүчний хэрэглээ ба ХХЯ (2013-2030)



Эх сурвалж: НУБХХ, НАМА төслийн баримт бичиг, 2016

Үндэсний онцлогт тохирсон ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагаа буюу НАМА гэж юу вэ?

Үндэсний онцлогт тохирсон ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагаа буюу ОУ-ын товчлолоор НАМА нь 2007 оны 12 дугаар сард НУБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцийн Балид болсон хурлаар анх томъёологдож, Балигийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Улс орнуудын ХХЯ-ыг бууруулах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн концепт, амлалт” болон тусгагджээ. НАМА-г хэрэгжүүлэхдээ дараах үндсэн 3 зарчмыг баримтлана:

- ❖ Улс орон бүр өөрсдийн үндэсний онцлогт тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэхдээ “нийтлэг боловч ялгавартай үүрэг хариуцлага” хүлээнэ.
- ❖ Хөгжиж буй орнууд сайн дурын үндсэн дээр хөгжингүй орнуудын санхүүгийн эх үүсвэр, техникийн тусламжтайгаар технологи шилжүүлэх суурьшуулах, чадавхи бэхжүүлэх чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- ❖ НАМА үйл ажиллагааны үр дүн нь “хэмжигдэж, тайлагнаж, нотлож” болохуйц байна.

ХҮРЭХ ҮР ДҮН, ХЭМЖИХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төслийн хугацаан дахь ХХЯ-ын бууралт : 10,709 тон CO₂-экв

Төслийн 3 дахь жилд ЭХ-ний хэрэглээ, ХХЯ-ын тооллогын системийг бий болгож, ашиглана

Төслийн 4 дэх жилд барилгын салбарын УОТХХЯ-ыг бууруулах 6 арга хэмжээг хэрэгжүүлэх

Төслийн 2 дахь жилд барилгын салбарын ХХЯ-ыг бууруулах үйл ажиллагааны MRV тогтолцоог бий болгоно

Цахилгаан эрчим хүчний хэмнэлт: 18,722 МВт

Шинэ барилга байгууламжууд барилгын норм, стандартыг 100% мөрдөнө

Барилгын ЭХХ-ийн чиглэлээр 50 ажлын байр шинээр бий болгоно

Тооллогын системийн тогтвортой үйл ажиллагааг хангаж ажиллах 4 байгууллагын уялдааг бий болгоно

Барилгын салбарт цаашид ХХЯ-ыг бууруулах арга хэмжээг санхүүжүүлэх байгууллагыг 3-аар нэмэгдүүлнэ

Төслийн 3 дахь жилд MRV тогтолцоог 2 байгууллагад хэрэгжүүлнэ

MRV-р баталгаажсан 3 НАМА-г хэрэгжүүлж, бодлогын баримт бичигт тусгуулна